Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анх дугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

17 дэх жилдээ
№67 (1372)

1964 оны
8 дугаар сарын 31

ДАВАА

## БАГШ

Анги танхимууд өглөөнөөс үдэш болтол хүүхдийн хөгжөөнтэй шуугианаар дүүрч байдаг цаг боллоо.

Энэ үед багш хүний нарийн төвөгтэй олон талтай ажил эхлэнэ. Сурагчдад олон талын гүн бат мэдлэг эзэмшүүлэх нь сургууль багш нарын гол зорилт мөн. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд багш хүн урьдах хичээлийн жилд хийсэн ажлынхаа амжилт дутагдлыг тал бүрээс нь судласны үндсэн дээр шинэ хичээлийн жилийн эхнээс хийх ажлаа нарийн төлөвлөгөөтэйгээр бэлтгэх хэрэгтэй байдаг.

Хичээлийн жил эхлэхийн өмнө сургууль багш нарын тэргүүн ээлжинд гүйцэтгэвэл зохих үүрэг бол сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамран сургах явдал мөн.

Удирдсан ангийнхаа сурагчдын өмнөх жилийн бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг судлаж сургуульдаа ирээгүй хүүхэд бүрийн шалтгааныг илрүүлж нэг ч хүүхдийг зав сардуулахгүйн төлөө тэмцэх хэрэгтэй.

Хичээлийн танхимуудын дотоод тохижилтыг шинэчлэн баяжуулж үзүүлэн таниулахуудыг сэлбэн засч хичээл явуулахад саадгүй болгоод хичээлийн төлөвлөгөө конспектийг программтайгаа тохируулан хийж гүйцэтгэх энэ бүх ажлууд хичээл эхлэхээс хэдэн хоногийн өмнө бэлтгэгдсэн байвал зохино.

Хичээлийн жил эхэлмэгц багш хүн ангид болон хичээлийн гадуур явуулах төрөл бүрийн ажлаа төлөвлөвөл зохино.

Хичээлийг үр дүнтэй явуулах нь багш хүн өөрөө зөвхөн мэргэжлийнхээ зүйлийг сайн эзэмшихийн хажуугаар онол, улс төрийн мэдлэг амьдралын баялаг туршлагыг хир зэрэг эзэмшинээс их шалтгаалдаг.

Энэ оны 6 дугаар сард болж өнгөрсөн нийгмийн ухааны багш нарын улсын зөвлөлгөөн энэ талаар чухал ач холбогдолтой заалт шийдвэр гаргаж өглөө.

Багшийн мэдлэгийн хүрээ хэдий чинээ өргөн, зохиож байгаа ажил нь олон талтай, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон байвал сурагчдын хүмүүжлийг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөө нь төдий чинээ их байна.

«Чөлөө цагтаа хүүхдүүдтэй ажиллахдаа баярладаг, тэдэнд сонирхолтой үлгэр яриаг ярихдаа дуртай байдаг, хүүхэлдэй, хөлөг онгоц, нисэх онгоц зэргийг хийж өгч тоглуулдаг, элдэв илбэ үзүүлдэг, тэд нартай хамт цэцэг навч, мод, чулуу түүж гербари коллекц хийдэг, одон ертөнцийн байдлыг таниулдаг, буудах, усанд сэлэхэд сургадаг хүмүүс бол ёстой сайн хүмүүжүүлэгчид мөн» гэж М. Горький бичиж байжээ.

Шавийн эрдэм багшаас гэж аргагүй үнэн үг. Хэрэв багш хүн хичээл заах, хүүхэдтэй ажиллах бүх ажилдаа урьдаас нарийн чанд бэлтгэж өөрөө цуцалтгүй сурч хүүхдийн амьдралд гүн орж чадвал сурлагын чанарыг сайжруулахад амжилт олж болно.

## Өндөр ургац даллаж байна



### Баянзүрхийнхэн багагүй туршлагатай

Баянзүрх сумын «Сүхбаатарын зам» нэгдлийнхэн байгалийн хадлан бэлтгэх талаар угийн туршлагатай билээ.

Тус сум-нэгдэл энэ жил 9500 тонн өвс бэлтгэх төлөвлөгөөтэй бөгөөд 8 дугаар сарын 25-ны мэдээгээр 2879 тонн өвс бэлтгэсэн юм. Байгалийн аюулаас болж тус сум—нэгдлийн хэмжээгээр 751 тонн өвс усанд алдсан боловч энэ сумын хадланчид байгальтай өрсөлдөн өвөл, хаврын хатуу бэрх улирлыг өнтэй давахын тулд өвс тэжээл арвин ихээр базаахаар цагийн боломж бүхнийг ашиглан хадлангийн ажилд шуурхайлан ажиллаж байна. Сум-нэгдлийн хэмжээгээр хадлангийн 15 бригад, трактор хадуур 2, морин хадуур 67, гар хадуур 89, хүн 366-тай Тэрэлж, Өгөөмөр, Дэндий, Даваапы өвөр зэрэг өвс ургамал жигдхэн, унац арвинтай газруудад гарч хадах ажлаа амжилттай явуулж байна. Сум-нэгдлийн захиргаа, намын үүр хадлангийн бригад, хадланчдын хооронд уралдаан зарлаж долоо хоногт нормоо 110 хувиар биелүүлсэн бригад хадагч, тармагч, бухалдагч, нуруулдагчдад 100 төгрөг, шилжин явах дарцаг, 100—105 хувь биелүүлсэн бригад, хадланчдад 50—75 төгрөг, үнэмлэхээр тус тус шагнах болзол гарган уралдааныг 7 хоногийн нэг дэх өдөр бүр дүгнэж байна.

Үхрийн 3 дугаар фермийн Чимэддорж даргатай Өгөөмөрийн хадланчид, үржил хонины нэгдүгээр бригадын Дэмбэрэл даргатай Долоон тохойн хадланчид, үйлдвэр бригадын Намхай даргатай Туулын шугуйн хадланчид бусад бригадуудаасаа түрүүлж болзолд заагдсан шан хүртжээ.

Хадланчдын хоорондын уралдаанд өсвөрийн залуу багачууд маань түрүүлж ахмад хадланчдынхаа манлайд явж байна.

Налайхын арван жилийн 9 дүгээр дунд сургуулийн 7 дугаар ангийн сурагч, тус сум-нэгдлийн аж ахуйн нярав Галбадрахын охин Алтанжаргал гар хадуураар өдөрт 0,8 га—гийн өвс хадаж 20 хоногт 21 тонн, 8 дугаар ангийн сурагч, нэгдлийн гишүүн Самдангийн хүү Цагаанчулуун гар хадуураар өдөрт 0,5 га-гийн өвс хадаж 20 хоногт 20 тонн өвс тус тус бэлтгэж болзлын нэгдүгээр шагналаар шагнагдан сургуульдаа ажлын бахдам амжилттай очицгоожээ.

Тус сум-нэгдлийн хадланчид өвс бэлтгэх ажилд өөр хоорондоо өрсөлдөөнтэй ажиллаж байгаа нь амжилт олохын үндэс болж байна.

Жишээ нь: Аймгийн аварга хадланчин Намрал, хадлангийн хугацаанд гар хадуураар 80 тонн өвс хадах үүрэг аваад 65 тонн өвс хадаад байхад, хадланчин Жамсран гар хадуураар 90 тонн өвс хадах үүрэг авч 100 тонн өвс хадаад байна.

Аварга хадланчин Намрал гар хадуур хоёрыг залгаж өдөрт 1 га илүү газрын өвс хадаж байна.

Тэрчлэн сум-нэгдлийн захиргаа, намын үүр суурь бүрт 300 кг, айл бүрт 100 кг хүчит тэжээл бэлтгэх үүрэг өгч одоо сум-нэгдлийн хэмжээгээр 10 гаруй тонн хүчит тэжээл бэлтгээд байна. Ийнхүү Баянзүрх сумын «Сүхбаатарын зам» нэгдлийн хадланчид өвөл хаврын өн болсон өвс хадланг цагийн сайханд арвин ихээр бэлтгэхийн тулд бололцоо бүхнээ дайчлан ажиллаж байна.

Манай сурвалжлагч Б. Дорж

## Хадлан Хадлан Хадлан



**Налайх хотын баруун урьд байдаг „Баянгийн бүрд" хэмээх газар хадланчдын майхан дэрвэн, хадуурын дуу хангинаж, мөр жирийж, бухал ярайж байна. Тэнд Баянзүрх сумын «Сүхбаатарын зам» нэгдлийн Самбуу даргатай хадлангийн 13 дугаар техник бригадынхан „ДТ—54" тракторт 7 морин хадуур агрегатлан өдөрт 30—40 га-гийн өвс хадаж байна. Зураг дээр: Хадланчид өвс хадаж байгаа нь:**

*Б. Доржийн авсан гэрэл зураг*

